

2020 он 4 сар 29 өдөр

Дугаар 0160

Улаанбаатар хот

АРД ДААТГАЛ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН

ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Хурлын огноо: 2020 оны 4 сарын 29-ний өдөр

Хурлын байршил: live.ard.mn цахимаар хуралдав.

Хурал эхэлсэн цаг: 14 цаг 00 минут

Хурлын дарга: Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүн О.Одбаяр

Хурлын ирц: Нийт саналын эрхтэй хувьцааны тоо 25,000,000 ширхэг, хуралд оролцож буй хувьцаа эзэмшигчдийн саналын эрхтэй хувьцааны тоо 22,020,448 ширхэг буюу 88.08 хувь

Хурлаар хэлэлцэх асуудал:

1. 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт;
2. Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан.

ТУЗ-ийн дарга Ч.Ганхуяг (Унгар Улсаас холбогдов): Ард Даатгал ХК-ийн нийт хувьцаа эзэмшигчид, үйлчлүүлэгчид та бүхэнтэйгээ Унгар Улсын Будапешт хотоос мэндчилж байна. Бид жилдээ нэг удаа хуран чуулж хувьцаа эзэмшигчиддээ компанийн үйл ажиллагаа, санхүүгийн тайлангаа танилцуулж та бүхнээс асуулт, шүүмж хүлээн авч, санал зөвлөгөөн өрнүүлдэг билээ. Шинэ коронавирус (Covid 19) цар тахлын хэмжээнд хүрч дэлхий даяар хөл хорио тогтоон ажлын шинэ горим тогтоон ажиллаж байгаа энэ үед бид ч мөн адил хувьцаа эзэмшигчдийн хурлаа цахимаар хийж байна. Бид хурлаа цахимаар хийж буй хэдий ч санал хураалтаа илүү хялбар, ойлгомжтой байдлаар явуулах, та бүхний асуултад хариулах бүхий л боломжийг хангаж бэлтгэлээ базаасан. Бид хурлын бэлтгэлийг хийх явцдаа дотоод хуулийн баг, Монголын Хөрөнгийн Бирж, Санхүүгийн Зохицуулах Хорооноос зөвлөмжийг авч ажилласан. Өнөөдрийн хурлыг ТУЗ-ийн шийдвэрийн дагуу томилогдсон Одончимэдийн Одбаяр даргална. Ингээд хувьцаа эзэмшигчид та бүхнийг хуралдаа идэвхтэй оролцохыг хүсч байна. Хурлын дарга О.Одбаярыг индэрт урьж байна.

Хурлын дарга О.Одбаяр: Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигч та бүхний энэ өдрийн амгаланг айлтгая. Ард Даатгал ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2020 оны 4 сарын 14-ны өдрийн 05/20 тоот тогтоолоор 2020 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар О.Одбаяр намайг томилсон билээ. Ийнхүү Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг нээснийг мэдэгдэж байна. Хурлын дэгийн дагуу хурлын ирцийг танилцуулна уу хэмээн тооллогын комиссын дарга Г.Алтансүхийг индэрт урьж байна.

Тооллогын комиссын дарга Г.Алтансүх: Энэ өдрийн мэндийг хүргэе. Хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын тогтоолыг танилцуулъя. Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн

67.3.1, 67.3.2 дахь хэсгийг тус тус үндэслэн тогтоох нь: Саналын эрх бүхий энгийн хувьцааны 22,020,448 ширхэг буюу 88.08 хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид хуралд оролцож байна. Саналын эрх бүхий энгийн хувьцааны 22,020,448 ширхэг буюу 88.08 хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид “Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай” санал хураалтад оролцоно.

Хурлын дарга О.Одбаяр: Хурлын ирцийг танилцуулсан тооллогын комиссын дарга Г.Алтансүхдээ баярлалаа. Ингээд хурлын хөтөлбөрийг та бүхэнд танилцуулъя. Өнөөдрийн хурлаар 2019 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах, Ард Даатгал ХК-ийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулах гэсэн 2 асуудлыг хэлэлцэнэ. Хэлэлцэх асуудлыг танилцуулсны дараа хэлэлцэх асуудалтай холбоотой асуултуудыг хувьцаа эзэмшигчдээсээ хүлээн авна. Үүний дараагаар 2019 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах асуудлаар санал хураалт явуулах ба санал хураалтын дүнг тооллогын комисс нэгтгэн танилцуулна. Ингээд хурлаас гарсан шийдвэрийг хурлын дарга хувьцаа эзэмшигчдэд танилцуулан хурлаа хаах юм. Хурлын дэгийн дагуу 2019 оны ТУЗ-ийн үйл ажиллагааны тайлан болон үйл ажиллагаа, санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг О.Одбаяр миний бие танилцуулна.

ТУЗ-ийн үйл ажиллагааны тайлан болон үйл ажиллагаа, санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт:

Бид 2018 оны 4 дүгээр улиралд Монголын Хөрөнгийн Бирж дээр IPO хийснээс хойш хоёр дахь удаагаа та бүгддээ ажлынхаа үр дүнг тайлагнаж байгааг хүлээн авна уу.

Манай ТУЗ-ийн зүгээс 2018 оны цэвэр ашгийн 50 хувийг буюу нийт 632 сая төгрөгийг ногдол ашгаар олгохыг шийдвэрлэж, 2019 оны 6 дугаар сард 1,600 гаруй хувьцааны эздэд оногдуулж, хуваарилсан билээ.

Дэлхий даяар цар тахлын аюултай тулж, улс орны эдийн засгийн нөхцөл байдал хүндэрч, бизнесийн борлуулалт, зах зээл эрс хумигдаж, зарим нь үүд хаалгаа хаах, ажилчдаа цомхтгох хүртэл арга хэмжээ авч буй энэ хүнд хэцүү үед ч бид хөрөнгө оруулагчиддаа өмнөх жилийн жишгээр ногдол ашиг хуваарилах шийдвэрийг гаргалаа. Компанийн 2019 оны цэвэр ашиг төлөвлөж байсан дүнгээс доогуур гарсан ч, өмнөх оны үзүүлэлттэй харьцуулбал 36 хувийн өсөлт үзүүлж, 1.7 тэрбум төгрөгт хүрлээ. Ингэснээр нэгж хувьцаанд ногдох ашиг 69 төгрөг болж байна. Үүний 50 хувийг нь бид хувьцаа эзэмшигчиддээ хүртээх бөгөөд 2020 оны 6 дугаар сарын эхээр та бүхэнд шилжүүлэх болно.

Ард Даатгал ХК нь 2019 оноо 11.8 тэрбум төгрөгийн өөрийн хөрөнгөтэй, нийт 20.8 тэрбум төгрөгийн хөрөнгөтэй үдлээ. 2019 оны эцсээр хураамжийн орлого 11.4 тэрбум төгрөг байсан ба цэвэр хураамжийн орлого 8.9 тэрбум төгрөгт хүрсэн байна. 2019 онд бид 5,152 даатгуулагчийн 4.4 тэрбум төгрөгийн хохирлыг нөхөн олгож, даатгалын гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүллээ. Тайлант хугацаанд манай компани давхар даатгалын компаниудтай амжилттай хамтран ажиллаж нийт хохирлын 10 хувь буюу 450 сая төгрөгийг давхар даатгагчаар төлүүлж, үлдэх хэсгийг өөрийн нөөц сангаас төлсөн болно. Олгосон нөхөн төлбөрийн дүн 2018 онтой харьцуулахад 26 хувиар буурсан байна.

2019 оны эцсээр компанийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт 123 хувьтай байсан ба хохирлын харьцаа 41 хувь, зардлын харьцаа 62.2 хувь, хосолсон харьцаа 103.2 хувьтай гарчээ. Хэдийгээр борлуулалтын төлөвлөгөөнд хүрээгүй ч чанарын үзүүлэлтүүд эрс сайжирч, зах зээлийн дунджаас сайн байж чадлаа.

Өнгөрсөн онд бид даатгалын борлуулалтыг цахимжуулах, гар утсаараа дамжуулан даатгал авах боломжийг нээх чиглэлээр бэлтгэл ажлуудыг хийн гүйцэтгэж, эхний ээлжинд Insur гар утасны аппликэйшн дээр өөрсдийн эрүүл мэндийн бүтээгдэхүүнийг байршуулан борлуулалтыг эхлүүлсэн. Үүний хажуугаар өөрсдийн Ард Апп шийдэл дээр даатгалын бүтээгдэхүүнийг оруулахаар технологийн компанитай хамтран ажиллаж, 2020 оны эхээр бүрэн нэвтрүүлэв. Энэхүү шийдлээр бид иргэдийн зах зээл дээрх борлуулалтыг үлэмж нэмэх боломжтой гэж үзэж байна. Даатгалын харилцагчиддаа Ард Койноор урамшуулал олгон, групп компаниудын бусад бүтээгдэхүүн үйлчилгээг авах боломжийг мөн эрчимтэй сурталчлан харилцагчийн баазаа өргөжүүлэх төлөвлөгөөтэй байна. Коронавирусын улмаас эдийн засаг, зах зээл хүнд нөхцөл байдалд байгаа ч 2019 онд биелүүлж амжаагүй амлалтуудыг 2020 онд нөхөн гүйцээх боломжтой гэж бид өөдрөгөөр харж байгаа.

2019 оны компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг ТУЗ-ийн зүгээс дүгнээд, удирдлагын багийн үйл ажиллагааг хангалттай гэж үнэлэн 2020 оны төсөв, төлөвлөгөөг баталж, улирал бүр гүйцэтгэлийг тайлагнаж явахыг үүрэгдсэн бөгөөд борлуулалтыг нэмэгдүүлэх, үйл ажиллагааны зардлыг хэмнэх, бүтээгдэхүүний нөхцөлийг сайжруулж, чанарын үзүүлэлтүүдийг зах зээлийн тэргүүний түвшинд барьж явах чиглэл өгч ажиллаж байна.

ТУЗ өнгөрсөн онд 5 удаа хуралдаж, ТУЗ-ийн дэргэдэх хороод мөн ээлжит хурлын өмнө уулзалдаж, ТУЗ-ийн хурлаар хэлэлцэх асуудал бүрийг урьдчилан танилцаж, дүгнэлт зөвлөмжийг боловсруулан ТУЗ-өөр хэлэлцүүлэн ажиллалаа.

Анхаарал тавьсан хувьцаа эзэмшигчиддээ баярлалаа. ТУЗ-ийн үйл ажиллагааны тайлан болон үйл ажиллагаа, санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг танилцуулж дууслаа. Хурлын дэгийн дагуу компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулна уу хэмээн Гүйцэтгэх захирал Г.Цогбадрахыг индэрт урьж байна.

Гүйцэтгэх захирал Г.Цогбадрах: Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигч, ТУЗ-ийн дарга, компанийн удирдлагын багийн гишүүд та бүхэндээ энэ өдрийн мэндийг дэвшүүлье. Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулъя.

2019 онд тохиосон онцлох үйл явдлууд:

-2019 оны 4 сарын 27-ны өдөр Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зохион байгуулж хурлаар ТУЗ-ийн гишүүдийг 2 жилийн хугацаатай сонгосон;

-

Ард Койныг урамшуулалт хөтөлбөр болгон үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн;
-Эрүүл мэндийн даатгалыг олон улсын зах зээлд нэвтрүүлэх, ард иргэддээ таниулах чиглэлд анхаарч ажилласан;

-Компанийн 25 жилийн ойгоор Үүсгэн байгуулагч Ц.Тогтохбаяр МУ-ын гавьяат эдийн засагч цолоор шагнагдсан;

-Дэлхийн эм зүйн аян ба эмнэлгийн менежментийн хурлыг хамтран зохион байгуулсан;

-Австралийн худалдаа аж үйлдвэрийн танхимын гишүүнээр элсэж, танхимаас зохион байгуулдаг арга хэмжээнүүдэд тогтмол хамтран ажилласан.

2020 эхний улирлын онцлох үйл явдлууд:

-Ard App-д эрүүл мэнд, гадаад зорчигч, тээврийн хэрэгслийн даатгалын бүтээгдэхүүнийг борлуулж эхэлсэн ба ойрын хугацаанд жолоочийн хариуцлагын даатгалыг програмд нэвтрүүлэхээр ажиллаж байна;

- 2019 оны цэвэр ашгаас нийт 850 сая төгрөг буюу 49.45 хувийг ногдол ашгаар тараахаар шийдвэрлэсэн;

-Шинэ коронавирус (Covid 19) цар тахлын хэмжээнд хүрсэнтэй холбогдуулан ажиллагсдын эрүүл мэндийг хамгаалан үе шаттай арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж байна;

Гүйцэтгэх захирал Г.Цогбадрах: Үйл ажиллагааны тайланг танилцуулж дууслаа. Ингээд санхүүгийн тайлангаа танилцуулъя.

2019 оны эцсээр бид нийт 1,637 хувьцаа эзэмшигчидтэй болсон. 2020 оны 4 сарын 9-ний өдрийн тархалтын мэдээгээр компанийн хувьцааны 84.8 хувийг 14 аж ахуйн нэгж, 15.2 хувийг нийт 1,742 гадаад болон дотоодын иргэд эзэмшиж байна. 2020 оны 4 сарын 9-ний өдрийн тархалтын мэдээнд үндэслэн 2020 оны ногдол ашгийг эхний улиралдаа багтаан тараах юм.

2019 оны хувьцааны арилжааны тухайд:

2019 оны туршид хамгийн доод үнэ 599 төгрөгт, дээд үнэ 800 төгрөгт хүрсэн байна. Оны эцэст компанийн зах зээлийн үнэлгээ 19.99 тэрбум төгрөг болж өссөн. 2019 онд нийт 2.18 тэрбум төгрөгийн арилжаа хийгджээ.

Хурлын дарга О.Одбаярын танилцуулсан санхүүгийн тайланг дэлгэрүүлж танилцуулав.

Г.Цогбадрах: Тайланг танилцуулж дууслаа. Хурлын хөтөлбөрийн дагуу асуулт, хариултын хэсэг эхэлж байна.

Хурлын дарга О.Одбаяр: Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулсан Г.Цогбадрах захиралд баярлалаа. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцож буй Ард Даатгал ХК-ийн удирдлагын багийн гишүүдийг танилцуулъя. Гүйцэтгэх захирал Г.Цогбадрах, Үйл ажиллагаа эрхэлсэн захирал А.Батболд, Санхүү удирдлагын газрын захирал Т.Батцэнгэл, Даатгалын газрын захирал Н.Эрдэнэтулга, Санхүүгийн шинжээч Г.Баярбат, Эрсдэлийн шинжээч Б.Нямдэлгэр, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн нарийн бичгийн дарга Э.Гэрэлчимэг нар хуралд оролцож байна.

Ингээд хувьцаа эзэмшигч нар Ард Даатгал ХК-ийн 2019 оны үйл ажиллагаа, санхүүгийн тайлантай холбоотой асуултаа илгээнэ үү.

Компанийн үйл ажиллагаа эрхэлсэн захирал А.Батболд хувьцаа эзэмшигчдээс цахимаар ирсэн асуултуудыг удирдлагын багийн гишүүдэд уншиж танилцуулав.

Хувьцаа эзэмшигч Л.Энхтайван: Ногдол ашиг жил болгон тараах уу?

Хувьцаа эзэмшигч Я.Батбаяр: Нэгж хувьцаанд хэдэн төгрөгийн ногдол ашиг тараах вэ? Шинээр ямар үйлчилгээ нэвтрүүлж байна вэ?

Хувьцаа эзэмшигч Э.Энхбаяр: Ипотекийн зээлийн даатгал Ард Апп-д хэзээ нэвтрэх вэ? гэсэн асуултууд ирсэн байна.

Гүйцэтгэх захирал Г.Цогбадрах: Асуулт ирүүлсэн хувьцаа эзэмшигчиддээ баярлалаа. Ард Даатгал ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс баталсан ногдол ашгийн журамд ногдол ашгийг жил болгон хуваарилах тухай заасан. Тус бодлогод тухайн жилийн цэвэр ашгийн 30-50 хувийг ногдол ашиг хэлбэрээр хувьцаа эзэмшигчиддээ хуваарилах тухай мөн зааж өгсөн. Энэ жилийн хувьд 2019 оны цэвэр ашгийн 49.45 хувь буюу нэгж хувьцаанд 34 төгрөгийн ногдол ашиг хуваарилна. Бид 2020 оны хоёрдугаар улиралдаа багтаан хувьцаа эзэмшигчдийн Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв дэх үнэт цаасны данс руу нь шилжүүлэхээр төлөвлөөд байна.

Хувьцаа эзэмшигч Я.Батбаярын асуултад хариулъя. Компани 2019 онд тээврийн хэрэгслийн даатгалын бүтээгдэхүүнд шинэчлэл хийсэн. Мөн Санхүүгийн Зохицуулах Хорооноос хадгаламжийн даатгалын бүтээгдэхүүний зөвшөөрлийг 2019 оны 12 сарын 27-ны өдөр олгосон. Тус бүтээгдэхүүнээ Хадгаламж зээлийн хоршоодод санал болгон хамтран ажиллахаар бэлдэж байна. 2020 онд байшин, орон сууц өмчлөгчийн даатгалыг Монгол Улсад нутагшуулахаар төлөвлөн давхар даатгалын компаниудтайгаа санал солилцож байна.

Хувьцаа эзэмшигч Э.Энхбаяр ипотекийн зээлийн даатгал Ард Апп-д хэзээ орох вэ гэж асуусан байна. Манай компани нь Төрийн Банк, Худалдаа Хөгжлийн Банк, Капитрон, Үндэсний Хөрөнгө Оруулалтын Банктай хамтран ажилладаг. Ипотекийн зээл нь арилжааны банкаар дамжин борлуулагддаг тул Ард Апп-д нэвтрүүлэх боломжгүй байна. Харин түрүүн дурдсанчлан орон сууц өмчлөгчийн даатгалын зөвшөөрлийг СЗХ-оос олговол Ард Апп-д нэвтрүүлэх боломжтой.

Хувьцаа эзэмшигч М.Энхдэлгэр: Ард Койныг зөвхөн урамшууллын бус идэвхтэй төлбөрийн хэрэгсэл болгохын тулд ямар ажил хийж байна вэ?

Гүйцэтгэх захирал Г.Цогбадрах: Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн бүхий л бүтээгдэхүүнийг Ард Койноор авч, ашиглах боломжтой. Жишээлбэл: Тээврийн хэрэгслийн даатгал, жолоочийн хариуцлагын даатгалыг Ард Койноор тухайн өдрийн ханшид тооцуулан худалдан авах боломжтой.

Ч.Ганхуяг: Ард Койн тун удахгүй шинэ бирж дээр арилжаалагдах болно. Ард Кредит ББСБ ХК нь Монгол Банкнаас цахим мөнгөний зөвшөөрлийг авахаар ажиллаж байна. Ингэснээр Ард Апп дээр цахим төлбөрийн хэрэгсэл нэвтрэх ба гадаадад байгаа монголчуудыг Ард Апп-д бүртгэх боломж нээгдэх юм. Харин Ард Койны хувьд цаашид урамшууллын оноо хэвээр байна. Ард Шопоос худалдан авалт хийн койноо нэмэгдүүлж тус койноороо худалдан авалт хийх боломжтой. Мөн бусад

төрлийн бүхий л үйлчилгээндээ ард койны урамшуулалт хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

Хувьцаа эзэмшигч Э.Цэдэн: Цар тахлын үед ямар бүтээгдэхүүн дээр төвлөрч ажиллах вэ? Ямар стратеги, төлөвлөгөөний дагуу ажиллаж байна вэ?

Гүйцэтгэх захирал Г.Цогбадрах: Монголын даатгалын зах зээлд голлох 4 бүтээгдэхүүн бол хөрөнгө, тээврийн хэрэгсэл, гэнэтийн осол, эрүүл мэндийн болон жолоочийн хариуцлагын даатгал юм. Цар тахлын үед ч мөн адил эдгээр бүтээгдэхүүндээ төвлөрч ажиллана. Цар тахал нь өмнө нь үүсч байгаагүй нөхцөл байдлыг бий болгож, ажил хөдөлмөр, амьдралын хэв маягийг нэлээдгүй өөрчлөөд байна. Иймээс бид энэхүү нөхцөл байдалд үндэслэн даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээг үзүүлэх чиглэлийг барьж ажиллаж байна.

Хувьцаа эзэмшигч Б.Цэцгээ: Жолоочийн хариуцлагын даатгалыг Ард Апп-д хэзээ нэвтрүүлэх вэ?

Гүйцэтгэх захирал Г.Цогбадрах: Жолоочийн хариуцлагын даатгалыг Ард Апп-д нэвтрүүлэхийн тулд бид Албан журмын даатгагчдын холбооноос зохих зөвшөөрлийг авах, Авто тээврийн Үндэсний төвтэй хамтран ажиллах гэх мэт үе шаттай арга хэмжээнүүдийг авч ажиллаж байна. Компанийн зүгээс техникийн бүхий л асуудлуудаа шийдсэн бөгөөд гуравдагч талуудын хариуг хүлээж байна.

Хувьцаа эзэмшигч Ц.Ариунцэцэг: Хувьцааны үнэ өсгөх хүрээнд ямар ажлууд хийгдэж байна вэ?

Гүйцэтгэх захирал Г.Цогбадрах: Хувьцааны дундаж ханш 710-720 төгрөг. Санхүүгийн шинжээчдийн дүгнэж буйгаар энэ ханш нь зах зээлийн үнэлгээнээс доогуур дүн. Компанийн зүгээс хувьцааны ханшид шууд нөлөөлөх боломжгүй. Харин компанийн үйл ажиллагаа, цар хүрээгээ өргөжүүлэх, ашиг орлогоо нэмэгдүүлэх, үйл ажиллагааны чанараа дээшлүүлэх замаар хувьцааны үнэ өсгөхийг эрмэлзэн ажиллаж байна.

Хувьцаа эзэмшигч Б.Ган-Эрдэнэ: Ард лайф ХХК-ийн бүтээгдэхүүнийг Ард даатгал ХК-ийн зүгээс үзүүлэх боломжтой юу? Нэйшнл лайф даатгал Ард лайфтай төстэй үйлчилгээ үзүүлдэг юм билээ.

Гүйцэтгэх захирал Г.Цогбадрах: Ард лайф ХХК-ийн бүтээгдэхүүн, үйлчилгээний талаар дэлгэрэнгүй мэдээллийг манай бүх салбаруудаас авах боломжтой. Ард лайф ХХК нь үндсэн 3 төрлийн бүтээгдэхүүнийг харилцагчиддаа санал болгож байна. Эдгээрийн нэг нь Ард Даатгал ХК-тай хамтарсан бүтээгдэхүүн бөгөөд багцад хөрөнгө оруулалт, эрүүл мэнд, гэнэтийн ослын даатгал, хуримтлал багтдаг.

Хувьцаа эзэмшигч М.Чойсүрэн: Хөндлөнгийн аудитын дүгнэлтээр анхаарах асуудлууд тодорхойлогдсон уу? Ард даатгал ХК-д дотоод аудит гэж байгаа юу? Тийм бол 2019 онд хэдэн удаа ямар үйл ажиллагаанд аудит хийсэн бэ?

Гүйцэтгэх захирал Г.Цогбадрах: Ард Даатгал ХК нь хоёр аудиторовн бүрэлдэхүүнтэй дотоод аудитын албатай. 2019 онд төв албаны санхүү, нөхөн төлбөрийн үйл ажиллагаанд аудит хийхийн хажуугаар орон нутгийн салбаруудад газар дээрх шалгалтыг хийсэн. Түүнчлэн ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороо байдаг. Компанийн тухай хуульд нийцүүлэн хороог ТУЗ-ийн хараат бус гишүүн даргалдаг. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурал болгоны өмнө дотоод аудитын алба нь аудитын хороонд ажлаа тайлагнадаг. Харин хөндлөнгийн аудитаар Далайван Аудит ХХК ажилласан.

Аудитын тайланд тусгагдсанаар компанийн санхүүгийн тайланг олон улсын стандарт, СЗХ-оос баталсан журмын дагуу шаардлага хангасан гэсэн дүгнэлт гарсан.

Хувьцаа эзэмшигч Д.Шагж: Сайн байцгаана уу? Та бүхэнд амжилт хүсье. Covid 19 цар тахал 2020 онд болон ойрын 2, 3 жилдээ даатгалын зах зээлд хэрхэн нөлөөлнө гэж үзэж байна вэ?

Гүйцэтгэх захирал Г.Цогбадрах: 2020 оны хувьд бүхий л аж ахуйн үйл ажиллагаа доголдож, орлогын хэмжээ буурч байна. Манай компанийн хувьд ч мөн адил бэлэн мөнгөний урсгалтай холбоотой асуудал үүсэхээр байна. Харилцагч компаниудын хувьд даатгалын хураамжаа хойшлуулах болсноор авлага нэмэгдэх цаашлаад төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлтэд нөлөөлөх магадлалтай. Иймээс даатгалын компаниуд хамтран СЗХ-нд төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлтийг бууруулах талаар хүсэлт тавьсан.

Хувьцаа эзэмшигч Т.Мөнх-Оргил: Хувьцаа эзэмшигч нартаа даатгал хийлгэхэд хөнгөлөлт, урамшуулал байгаа юу?

Гүйцэтгэх захирал Г.Цогбадрах: Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын хувьд ямар нэгэн хөнгөлөлт урамшуулал олгохыг хуулиар хориглосон байдаг. Иймд албан журмын даатгал дээр хөнгөлөлт урамшуулал гэж байхгүй, гэхдээ тухай жил осол гаргаагүй бол итгэлцүүрийн бодолтоороо төлөх дүн нь буурч гардаг. Харин сайн дурын даатгалууд, жишээлбэл тээврийн хэрэгслийн даатгал, хөрөнгийн даатгал зэрэгт хувьцаа эзэмшигч нартаа зориулаад урамшуулалтай, хямдралтай аян зарлаад явдаг. Бид хувьцаа эзэмшигчиддээ зориулсан байнгын хөнгөлөлт, урамшуулалтай болохоор судалж байна.

Хувьцаа эзэмшигч Ж.Нямцэцэг: Цахим даатгалын систем нэвтрүүлж байгаатай холбогдуулан хүний нөөцийн бодлогод өөрчлөлт гарах уу?

Гүйцэтгэх захирал Г.Цогбадрах: Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс цар тахлын үед ажлын байрыг тогтвортой хадгалах, ажлын байр цомхтогхгүй байх, хүний нөөцийн бодлогоо тогтвортой хадгалах чиглэлийг өгсөн. Цахим даатгалын үйлчилгээг нэвтрүүлсэн нь үйл ажиллагаагаа өргөтгөж буй үйл явдал бөгөөд хүн хүчээ багасгаж буй үйл явц биш юм.

Хурлын дарга О.Одбаяр: 2019 оны үйл ажиллагаа, санхүүгийн тайлантай холбоотой асуулт хариултын хэсэг өндөрлөж байна. Хурлын дэгийн дагуу 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай санал хураалт 10 минутын турш явагдах бөгөөд саналаа хэрхэн өгөх талаар заавар бичлэгт анхаарлаа хандуулахыг нийт хувьцаа эзэмшигчдээсээ хүсье.

Санал хураалтын заавар бичлэгийг үзүүлсний дараа санал хураалт 10 минутын турш үргэлжлэв.

О.Одбаяр: 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай санал хураалт явагдаж дууссан байна. Ард Даатгал ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссоор Г.Алтансүх, Б.Мөнхзул, Б.Ариунзул нар ажилласан болно. Ингээд санал хураалтын дүнг танилцуулна уу хэмээн тооллогын комиссын дарга Г.Алтансүхийг индэрт урьж байна.

Г.Алтансүх: Та бүхэнд тооллогын комиссын тогтоолыг уншиж танилцуулъя. Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.3.8 дахь хэсгийн дагуу Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцсон болон саналын хуудсаар урьдчилан ирүүлсэн саналыг тоолж санал хураалтын дүнг нэгтгэснийг үндэслэн тогтоох нь: Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай санал хураалтад 22,020,448 ширхэг хувьцаа буюу 88.08 хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид оролцсоноос 21,948,698 ширхэг буюу 99.67 хувийг эзэмшиж буй хувьцаа эзэмшигчид зөвшөөрсөн саналыг өгсөн ба татгалзсан, түдгэлзсэн санал ирээгүй. Компанийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.5 дахь хэсэгт зааснаар шийдвэр хүчинтэй. Тооллогын комиссын тогтоолыг танилцуулж дууслаа. Баярлалаа.

О.Одбаяр: Тооллогын комиссын гишүүд, даргадаа баярлалаа. Ингээд Ард Даатгал ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тогтоолыг уншиж танилцуулъя.

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх хэсэг, 2020 оны 4 сарын 29-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын Тооллогын комиссын 20/02 тоот тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Ард Даатгал ХК-ийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх дүгнэлтийг баталсугай.

Ийнхүү хувьцаа эзэмшигчдийн шийдвэрээр тогтоолыг баталсныг мэдэгдэе. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудлыг баталснаар амжилттай өндөрлөлөө. Хурлаа амжилттай зохион байгуулсан Ард Даатгал ХК-ийн ТУЗ-ийн гишүүд, удирдлагын баг, Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн удирдлагын багт талархлаа илэрхийлье. Хувьцаа эзэмшигчидээ баярлалаа. Хурлыг хаасныг албан ёсоор мэдэгдэж байна.

ХУРЛЫН ДАРГА



О.ОДБАЯР

Тэмдэглэл хөтөлсөн:

ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА *Э.Гэрэлчимэг* Э.ГЭРЭЛЧИМЭГ